



# БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

## 2016/1



# СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?


[www.1212.mn](http://www.1212.mn)





СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН  
НЭГДСЭН САН



[www.nso.mn](http://www.nso.mn) сайтын  
Хэрэглэгчийн бүртгэлд  
бүртгүүлснээр цахим  
хаягаар тогтмол  
авч болно.



Monstat ezStat  
аппликейшн



1900-1212



Лавлах утас

@statistic\_mn



Статистик  
мэдээлэл



Үндэсний Статистикийн  
Хорооны  
НОМЫН САН



Онлайн лавлах  
мессенжер  
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ  
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ  
ХҮРГЭНЭ

## ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	5
Үндсэн үзүүлэлтүүд.....	12
I. 1 Хөдөлмөр .....	13
I. 2 Нийгмийн даатгал.....	13
I. 3 Эрүүл мэнд .....	14
I. 4 Гэмт хэрэг .....	15
II.2 Үнэ.....	17
II.6 Мал аж ахуй.....	22

## Аргачлалын тайлбар

### Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

### Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

### Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

### Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

### Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

### Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

### Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

$I_p^L$  -  $t$  тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

$t$  - тайлант үе

$o$  - суурь үе

$p_{it}$  -  $i$  барааны тайлант үеийн үнэ,

$p_{io}$  -  $i$  барааны суурь үеийн үнэ,

$q_{io}$  -  $i$  барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

$\sum$  - нийлбэрийн тэмдэг

### Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

### Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V, ... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

## I. Нийгмийн үзүүлэлт



### I.1 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэд 2016 оны 1 дүгээр сарын байдлаар 501 болсны 236 нь буюу 42.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Тайлант хугацаанд 162 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 18 иргэн ажилд зуучлагдан орж, 90 иргэн ажил идэвхитэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэнд 16 хүн буюу 10.9 хувиар өсч, ажилд зуучлагдан орсон иргэд 4 хүн буюу 18.1 хувь, ажил идэвхитэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 155 хүнээр буюу 63.2 хувиар буурчээ.

Зураг I.1

Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон болон хасагдсан иргэд жил бүрийн 1-р сарын байдлаар



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 19 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 3.5 хувийг тусгай мэргэжлийн дунд, 7.2 хувийг техникийн болон мэргэжлийн, 56.4 хувийг бүрэн дунд боловсролтой, 9.8 хувийг суурь боловсролтой, 2.6 хувийг бага боловсролтой, 1.6 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр 2016 оны 1 дүгээр сарын байдлаар, хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 13.4 хувийг 15-24 насны, 33.5 хувийг 25-34 насны, 29.7 хувийг 35-44 насны, 19 хувийг 45-54 насны, 3.7 хувийг 55-59 насны, 0.7 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.



### I.2. Нийгмийн даатгал, халамж

#### Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны 1-р сард 771.9 сая төгрөг, зарлага 2411.5 сая төг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 114.4 сая төг буюу 17.4 хувь, зарлага 367 сая төг буюу 18 хувиар өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлого 114.4 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 54.6 сая.төг буюу 13 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 10.1 сая.төг буюу 21.5 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 4 сая.төг буюу 38.1 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сан 24.4 сая.төг буюу 78.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 367 сая.төг буюу 18 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 305.3 сая.төг буюу 16.6 хувиар, ҮОМШӨ даатгалын сан 3.6 сая.төг буюу 21.8 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 63.4 сая.төг буюу 71.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн бол тэтгэмжийн даатгалын сан 0.8 сая.төг буюу 0.9 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 4.5 сая.төг буюу 29.4 хувиар буурсан байна.

## Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 1 сард 218.6 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 461.7 сая.төг буюу 26.8 хувиар өсчээ. Үүний 26.2 сая.төг буюу 25 хувийг халамжийн тэтгэвэр, 19.9 сая.төг буюу 29.5 хувийг нь нөхцөлт мөнгөн тэтгэмжинд зарцуулсан байна. Халамжийн сангаас олгосон нөхцөлт мөнгөн тэтгэмжийн 42.6 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл эхчүүдэд олгосон тэтгэмж, 37.1 хувийг ахмад настанг асарч буй иргэнд олгосон тэтгэмж, 19.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгосон тэтгэмж, 0.7 хувийг бүтэн өнчин хүүхэд өсгөсний тэтгэмж эзэлж байна.




### I.3 Эрүүл мэнд

2016 оны 1-р сарын байдлаар 73 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 74 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 17 буюу 18.9 хувь, амьд төрсөн хүүхдийн тоо 16 буюу 17.8 хувиар буурсан байна.

Зураг I.3


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, сүүлийн 3 жилийн 1-р сарын байдлаар



Нялхасын эндэгдэл 2016 оны 1-р сарын байдлаар 1 болсон нь өмнөх оны мөн үеийнхтэй адил байна.

Зураг I.4


Эндсэн хүүхэд, сүүлийн 3 жилийн 1-р сарын байдлаар



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2016 оны 1-р сарын байдлаар 49 болж, өмнөх оны мөн үеийнхээс 16 тохиолдол буюу 32 хувиар өссөн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 26 буюу 53 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна

Зураг I.5

Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сүүлийн 3 жилийн 1-р сарын байдлаар



### I.4 Байгаль орчин

#### Цаг уурын урьдчилсан мэдээ

Энэ сарын агаарын температурын дундаж нь 15-20 градус хүйтэн

буюу Тэшиг, Рашаант, Дашинчилэн, Баяннуур зэрэг сумд болон Гурванбулагийн өмнөд хэсгээр олон жилийн дунджийн орчим бусад нутгаар дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байна.

Нэг ба гуравдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч чангарч томоохон голын хөндийгөөр шөнөдөө 31-36 градус, өдөртөө 17-22 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 24-29 градус, өдөртөө 13-18 градус хүйтэн байна. Харин хоёрдугаар арав хоногийн эхний хагаст болон гуравдугаар


арав хоногийн сүүлчээр хүйтний эрч суларч томоохон голын хөндийгөөр шөнөдөө 21-26 градус, өдөртөө 9-14 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 15-20 градус, өдөртөө 4-9 градус хүйтэн байна. Бусад хугацаанд томоохон голын хөндийгөөр шөнөдөө 24-29 градус, өдөртөө 12-17 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 18-23, өдөртөө 8-13 градус хүйтэн байна.

Энэ сард орох хур тунадас нь нутгийн баруун хойд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр нутгийн хойд хэсгээр, хоёрдугаар арав хоногийн сүүлийн хагаст ихэнх нутгаар цас орох төлөвтэй.

Салхи нэг ба гуравдугаар арав хоногийн сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр 12-14 м/с, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуур 16-18 м/с хүртэл ширүүсч цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй байна.

Зураг I.6  
2-р сарын агаарын температурын хоногийн явц



2016 оны 03, 04 дүгээр сарын цаг агаарын төлөв:

Гуравдугаар сард. Энэ сарын агаарын температурын дундаж нь 5-10 градус хүйтэн буюу олон жилийн дунджийн орчим байна.

Ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас ахиу хур тунадас орох төлөвтэй. /5мм-с ахиу.

Дөрөвдүгээр сард. Агаарын температурын сарын дундаж нь ихэнх нутгаар уур амьсгалын дунджийн орчим, Баян-Агт, Сайхан, Могод зэрэг сумдын нутгаар дунджаас 0.5 градусаар дулаан байх төлөвтэй.

Нутгийн хойд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.




## I.5 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2016 оны 1 сарын байдлаар 32 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10 хэргээр буюу 45,5 хувиар өссөн байна. БҮСТЗЭТХэрэг 11 бүртгэгдэн 4 хэргийг илрүүлж, гэмт хэргийн илрүүлэлт 36,4 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 13,6 хувиар буурсан байна. Гэмт хэргийн гаралт Баян-Агт, Хутаг-Өндөр, Хангал, Орхон, Булган, Могод сумдад гэмт хэргийн гаралт урьд оны мөн үеийнхээс өсч, Бугат, Рашаант, Бүрэгхангай, сумдад урьд оны мөн үеийнхтэй ижил түвшинд, бусад сумдад гэмт хэргийн гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс буурсан байна.

Зураг I.7

Бүртгэгдсэн гэмт хэрэг, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



Хэргийн өнгөөр нь авч үзвэл


- ИЭЧЭМЭГХ 13 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4 хэргээр буюу 30,7 хувиар
- Хулгайн гэмт хэрэг 9 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3 хэргээр буюу 33,3 хувиар
- Хүнийг санаатай алах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 100 хувиар
- Танхайрах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 100 хувиар
- Албан тушаалын эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 100 хувиар тус тус өссөн байна.
- Мал хулгайлах гэмт хэрэг 6 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй ижил түвшинд
- ХАБАЖЭГХ 1 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеийнхээс 2 хэргээр буюу 66,6 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын тухайд Гэмт хэргийн улмаас нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 27,3 төгрөгний

хохирол учирснаас иргэдэд 27,3 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд 12 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж ажилласан.

Зураг I.8


Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн эхний 1 сарын байдлаар, сая төг



Гэмт хэргийн улмаас 5 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 40 хувиар өссөн байна. Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн улмаас 3, бусдыг санаатай алах гэмт хэргийн улмаас 1, бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн улмаас 1 иргэн тус тус амь насаа алдсан байна. Гэмт хэргийн улмаас 11 хүн гэмтсэн ба ИЭЧЭМЭГХ-ын улмаас 8, ХАБАЖЭГХ-ийн улмаас 1 хүн бусад хэргийн улмаас 2 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1 буюу 9 хувиар өссөн байна.

Зураг I.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүн, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд Бүртгэгдсэн нийт хэргийн 10 хэрэг нь согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг байгаа нь нийт хэргийн 31,2 хувийг эзэлж байна. Өнгөрсөн онд согтуугаар 12 хэрэг үйлдэгдсэн бол энэ онд 2 хэргээр буюу 16,6 хувиар тус

тус буурсан.

Гэмт хэрэг үйлдэгсдийн талаар 32 гэмт хэрэгт 25 хүн холбогдсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10 буюу 40 хувиар буурсан байна. 2016 оны 1 сарын байдлаар 539 зөрчил бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 35,1 хувиар буурсан байна. 2016 оны эхний 1 сарын байдлаар гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсгны улмаас 53 хүн эрүүлжүүлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2 хүнээр буюу 3,6 хувиар буурсан бол, захиргааны журмаар 3 хүнийг баривчлах шийтгэл эдлүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 7 хүнээр буюу 70 хувиар буурсан байна. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж, торгуулсан 20 иргэн байна.

## II. Эдийн засгийн үзүүлэлт


### II.1 Аймгийн төсөв

Төсвийн нийт орлого 2016 оны 1-р сарын байдлаар 2695.1 сая төгрөг, зарлага 3198.8 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл -503.7 сая төгрөг сөрөг гарлаа.

Орон нутгийн төсвийн орлогын 10.7 хувийг татварын орлого, 0.7 хувийг татварын бус орлого, 88.6 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Аймгийн төсвийн зарлагын хэмжээ 2016 оны 1-р сард 3198.8 сая.төг болоход 82.3 хувийг бараа материалын зардал, 17.3 урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.



Зураг II.1

Аймгийн төсвийн орлого, зарлага сүүлийн 3 жилийн 1-р сарын байдлаар, сая төг



Нийт авлага 3.2 сая, өглөг 642.1 сая төгрөг байна. Нийт өглөгөөс цалин, НДШ-ийн өр 102.4 сая төг, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны өр 363.7 сая төг, эмийн өр 3.1 сая төг, бусад зардлын өглөг 172.9 сая төг төгрөг байна.


Зураг II.2



Хүснэгт II.1

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2016 I 2015 I	2016 I 2015 XII
Ерөнхий индекс	100.0	102.4	101.1
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	100.3	102.0
Согтууруулах ундаа, тамхи	3.2	101.9	100.3
Хувцас, бөс, бараа, гутал	16.1	98.4	101.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	105.9	101.9
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	102.8	100.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	99.2	100.0
Тээвэр	12.2	103.7	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	99.9	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	132.5	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	109.7	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	104.3	101.1



II.2 Үнэ

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2016 оны эхний 1 сард адууны шир 30.0 мян.төгрөг, үхрийн 1.8-2.3 м урттай шир 20.4 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 37.0 мян.төгрөг, хонины нэхий 0.7 мян.төгрөг, ямааны арьс 8.2 мян.төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхээс адууны шир 14.2 хувиар, үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 49 хувиар, 2.3 метрийн урттай шир 38.3 хувиар буурсан байна.

Малын дундаж үнэ: 2016 оны 1 сард тэмээ 840 мян.төг, адуу 611.3 мян.төг, үхэр 825 мян.төг, хонь 120 мян.төг, ямаа 88.1 мян.төг болж буюу өмнөх оны мөн үеийнхээс тэмээ 17.6 хувиар, адуу 22.6 хувиар, үхэр 25.6 хувиар, хонь 25.5 хувиар, ямаа 23 хувиар тус тус буурчээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2016 оны 1 дугаар сард өмнөх сарынхаас 0.6 хувиар буурсан, оны эхнээс 1.1 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 2.4 хувиар өслөө.

Зураг II.3

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)

Зураг II.4  
Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2016 I, 2015 II-XII сар, (өмнөх сар=100%)





## II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны эхний 1 сард 1026.7 сая.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 256.4 сая.төг буюу 24.9 хувиар өссөн байна. Үүнд боловсруулах аж үйлдвэр 223.2 сая төгрөг буюу 58 хувиар, уул уурхай олборлох аж үйлдвэр 13.4 сая буюу 9 хувиар, цахилгаан дулаан, эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж 18 сая буюу 11 хувиар өслөө

### Хүснэгт II.2

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, жил бүрийн эцэст

Аж үйлдвэрийн салбар	2015 I	2016 I	2016 I 2015 I
Нийт дүн	770	1026.7	134
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	147.3	160.7	109
Боловсруулах аж үйлдвэр	471.8	695	158
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	152	170	111

Аж үйлдвэрийн салбар нь 2016 оны эхний сард 1488,5 сая төгрөгний бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 36 хувиар өссөн байна. Нийт борлуулалтын 180 сая төгрөг буюу 43,7 хувийг уул уурхай салбар 881 сая төгрөг буюу 34 хувийг боловсруулах аж үйлдвэрийн салбар, 427,5 сая төгрөг буюу 17 хувийг цахилгаан дулааны үйлдвэрлэлт эзэлж байна.

### Зураг II.5

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт, дэд салбараар, дүнд эзлэх хувь, жил бүрийн эцэст



## II.6 Хөдөө аж ахуй Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 2016 оны эхний 1 сард 3.6 мян. толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.8 мян.толгой мал буюу 4.4 дахин хувиар өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 0.2 мянга, үхэр 0.3 мянга, хонь 1.4 мянга, ямаа 1.5 мянга хорогдоод байна. Нийт хорогдлын 40.6 хувийг хонь, 43.3 хувийг ямаа эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Хишиг-Өндөр сум 11.5 хувийг, Дашинчилэн сум 17.5 хувийг, Гурванбулаг сум 26.6 хувийг эзэлж байгаа нь дийлэнх болж байна. Өвчнөөр хорогдсон мал 37 болж өмнөх оны мөн үеийнхээс 24 толгой буюу 39.3 хувиар буурсан байна.


### Зураг II.6

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, эхний 1 сарын байдлаар, толгой



### Зураг II.7

Том малын зүй бусын хорогдол



Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2016 оны эхний 1 сард адууны шир 30.0 мян.төгрөг, үхрийн 1.8-2.3 м урттай шир 20.4 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 37.0 мян.төгрөг, хонины нэхий 0.7 мян.төгрөг, ямааны арьс 8.2 мян. төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхээс адууны шир 14.2 хувиар, үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 49 хувиар, 2.3 метрийн урттай шир 38.3 хувиар буурсан байна.

Малын дундаж үнэ: 2016 оны 1 сард тэмээ 840 мян.төг, адуу 611.3 мян.төг, үхэр 825 мян.төг, хонь 120 мян.төг, ямаа 88.1 мян. төг болж буюу өмнөх оны мөн үеийнхээс тэмээ 17.6 хувиар, адуу 22.6 хувиар, үхэр 25.6 хувиар, хонь 25.5 хувиар, ямаа 23 хувиар тус тус буурчээ.

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН  
ХЭЛТЭС

## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эцэст

Үзүүлэлтүүд	2014 I	2015 I	2016 I	2016 I 2015 I
<b>Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд</b>				
Төрсөн хүүхэд	78	90	74	82%
Бүртгэлтэй ажилгүй иргэд 12 дугаар сарын эцэст		744	573	77%
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	43	33	49	148%
Бүртгэгдсэн гэмт хэрэг	34	22	32	145%
Нийгмийн даатгалийн орлого	649.4	657.5	771.9	117%
Нийгмийн даатгалийн зарлага	1615.1	1834.1	2139.4	116%
<b>Макро эдийн засгийн үзүүлэлтүүд</b>				
Орон нутгийн төсвийн орлого, сая.төг	1472.6	3165.1	2695.1	85%
Орон нутгийн төсвийн зарлага, сая.төг	2230.9	2603.2	3198.8	122%
Адууны дундаж үнэ /нас гүйцсэн/	-	790625	611333	77%
Үхэрийн дундаж үнэ /нас гүйцсэн/	-	1109375	825000	80%
Тэмээний дундаж үнэ /нас гүйцсэн/	-	1020000	840000	82%
Хониний дундаж үнэ /нас гүйцсэн/	-	161250	120000	74%
Ямааны дундаж үнэ /нас гүйцсэн/	-	114563	88125	77%
Хэрэглээний үнэ		102.4	101.1	98%
<b>Эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд</b>				
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, жил бүрийн 1-р сарын байдлаар, сая.төг	649.4	768.5	771.9	100%
-Уул уурхай, олборлох аж үйлдвэр	234.7	147.3	147.3	100%
-Боловсруулах аж үйлдвэр	268.4	469.2	471.8	100%
-Цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамж	138	152	152	100%

## I.1 ХӨДӨЛМӨР

Үзүүлэлт	2015 I		2016 I		$\frac{2016 I}{2015 I}$	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эхэнд/	843	363	501	236	59.4	65.0
Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн	146	74	162	85	111.0	114.9
Тайлант хугацаанд хасагдсан иргэн /идвэхгүйн улмаас/	245	88	90	58	36.7	65.9
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	744	349	573	263	77.0	75.4
Ажилд зуучлагдан орсон иргэн /салбараар/	22	11	18	13	81.8	118.2
Хувьцаат компани	-	-	-	-	-	-
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	15	8	2	2	13.3	25.0
Нөхөрлөл, хоршоо	-	-	2	1	-	-
Төрийн өмчит үйлдвэрийн газар	-	-	-	-	-	-
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	-	-	-	-	-	-
Төсөвт байгууллага	5	1	5	5	100.0	500.0
Төрийн бус байгууллага	-	-	-	-	-	-
Сан	-	-	-	-	-	-
Бусад	2	2	-	-	-	-
Ажил хайгч иргэн (насны бүлгээр)	744	349	573	263	77.0	75.4
15-24	135	72	77	37	57.0	51.4
25-34	213	103	192	89	90.1	86.4
35-44	177	85	170	88	96.0	103.5
45-54	181	79	109	44	60.2	55.7
55-59	30	9	21	4	70.0	44.4
60+	8	1	4	1	50.0	100.0
Ажил хайгч иргэн (боловсролын түвшнээр)	744	349	573	263	77.0	75.4
Магистр, доктор	3	2	0	0	0.0	-
дипломын болон бакалаврын дээд тусгай мэргэжлийн дунд	114	71	109	77	95.6	108.5
техникийн болон мэргэжлийн бүрэн дунд	26	16	20	9	76.9	56.3
суурь	47	19	41	15	87.2	78.9
бага	375	179	323	136	86.1	76.0
боловсролгүй	140	50	56	23	40.0	46.0
	31	11	15	3	48.4	27.3
	8	1	9	0	112.5	-

## I.2 НИЙГМИЙН ДААТГАЛ

Үзүүлэлтүүд	2014 I	2015 I	2016 I	2016 I / 2015 I
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	649.4	657.5	771.9	117.4
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	438.5	420	474.6	113.0
Тэтгэмжийн даатгалын сан	47.9	46.9	57	121.5
Эрүүл мэндийн даатгалын сан	120.5	149	170.3	114.3
ҮОМШӨ*-ний даатгалын сан	31	31.1	55.5	178.5
Ажилгүйдлийн даатгалын сан	11.5	10.5	14.5	138.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	1615.1	2044.4	2411.4	118.0
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	1397.4	1834.1	2139.4	116.6
Тэтгэмжийн даатгалын сан	54.6	89.5	88.7	99.1
Эрүүл мэндийн даатгалын сан	139	89	152.4	171.2
ҮОМШӨ*-ний даатгалын сан	15	16.5	20.1	121.8
Ажилгүйдлийн даатгалын сан	9.1	15.3	10.8	70.6

## I.3 ЭРҮҮЛ МЭНД

*Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр жил бүрийн 1-р сарын байдлаар*

Үзүүлэлт	2015 I	2016 I	2016 I / 2015 I
Амаржсан эхийн тоо	90	73	81%
Амьд төрсөн хүүхэд	90	74	82%
Эхийн эндэгдэл	-	-	0%
Амьгүй төрөлт	1	-	0%
Гэрийн төрөлт	-	1	100%
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	1	1	100%
Перинаталь эндэгдэл	2	1	50%
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	11.1	13.5	122%

*Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, жил бүрийн 1-р сарын байдлаар*

Үзүүлэлт	2015 I	2016 I	2016 I / 2015 I
Нийт гарсан халдварт өвчин	33	49	148%
Гэдэсний халдварт өвчин	2	0	0%
Амьсгалын замын халдварт өвчин	9	18	200%
Байгалын голомтот халдварт өвчин	0	0	0%
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	18	26	144%
Арьсны халдварт өвчин	4	5	125%

## I.4 ГЭМТ ХЭРЭГ

*Бүртгээгдсэн гэмт хэрэг, жил бүрийн 1-р сарын байдлаар*

Сум	2012 I	2013 I	2014 I	2015 I	2016 I	2016 - I % 2015 - I
Булган	10	13	7	8	9	112.5
Баян-Агт	0	0	1	0	1	-
Баяннуур	0	0	1	0	0	-
Бугат	1	2	2	2	2	100
Бүрэгхангай	2	2	3	4	4	100
Гурванбулаг	1	0	4	1	1	100
Дашинчилэн	0	0	0	1	1	100
Могод	1	4	0	1	3	300
Орхон	1	6	0	2	7	350
Рашаант	1	4	1	1	1	100
Сайхан	1	2	3	0	0	-
Сэлэнгэ	1	3	2	0	0	-
Тэшиг	1	1	0	0	0	-
Хангал	0	2	3	0	2	-
Хишиг- Өндөр	1	7	3	2	0	0
Хялганат	1	1	1	0	0	-
Хутаг-Өндөр	1	0	3	0	1	-
Бүгд	23	45	34	22	32	145.5

*Хулгайн гэмт хэрэг, сумаар, жил бүрийн 1-р сарын байдлаар*

Сум	2012 I	2013 I	2014 I	2015 I	2016 I
Булган	8	7	2	-	1
Баян-Агт	-	-	-	-	-
Баяннуур	-	-	1	-	-
Бугат	1	-	1	-	2
Бүрэгхангай	1	-	1	2	1
Гурванбулаг	1	1	4	1	-
Дашинчилэн	-	-	-	1	-
Могод	1	4	-	-	2
Орхон	-	5	-	1	3
Рашаант	-	2	1	1	-
Сайхан	-	-	3	-	-
Сэлэнгэ	1	1	2	-	-
Тэшиг	-	-	-	-	-
Хангал	-	-	1	-	-
Хишиг-Өндөр	-	3	3	-	-
Хутаг-Өндөр	1	3	1	-	-
Хялганат	-	1	-	-	-
Бүгд	14	27	20	6	9

## Сумдын хэргийн илрүүлэлт 2016 оны эхний 1 сарын байдлаар

Сум	Бүртгэгдэх үедээ сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг	Илрээгүй хэрэг	Яллагдагчаар татаж ял сонсгосон хэрэг	Хэргийн илрүүлэлтийн хувь
Булган	1	1	0	0.00
Баян-Агт	-	-	-	-
Баяннуур	-	-	-	-
Бугат	2	1	1	50,00%
Бүрэгхангай	1	1	0	0%
Гурванбулаг	-	-	-	-
Дашинчилэн	-	-	-	-
Могод	2	1	1	50%
Орхон	5	3	2	40.00%
Рашаант	-	-	-	-
Сайхан	-	-	-	-
Сэлэнгэ	-	-	-	-
Тэшиг	-	-	-	-
Хангал	-	-	-	-
Хишиг-Өндөр	-	-	-	-
Хутаг-Өндөр	-	-	-	-
Хялганат	-	-	-	-
Бүгд	11	7	4	36.40%

## Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн 1-р сарын байдлаар

Үзүүлэлт	2011 I	2012 I	2013 I	2014 I	2015 I	2015 I % 2014 I
	сая төгрөг					
Учирсан хохирол- Бүгд	53.3	506.0	990.5	904	237.0	26.2
Үүнээс						
Нөхөн төлүүлсэн	274.5	85.9	750.0	105.0	120.5	114.8
Нөхөн төлүүлэлтийн хувь	515.0	17.0	75.7	11.6	50.8	437.7

## II.2 ҮНЭ

## Хэрэглээний үнийн ерөнхий индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2016 I 2015 I	2016 I 2015 XII	2016 I 2015 XII
Ерөнхий индекс	102.4	101.1	101.1
Хүнсний бараа, ундаа, ус	100.3	102.0	102.0
Согтууруулах ундаа, тамхи	101.9	100.3	100.3
Хувцас, бөс бараа гутал	98.4	101.6	101.6
Орон сууц, ус цахилгаан, түлш	105.9	101.9	101.9
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.8	100.0	100.0
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	99.2	100.0	100.0
Тээвэр	103.7	100.0	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	99.9	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	109.7	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	104.3	101.1	101.1

## Хүнсний гол нэр төрлийн барааны 7 хоногийн ажиглалт 2015 оны 1-р сарын сүүлийн 7 хоног, 2016 оны 1-р сарын сүүлийн 7 хоногтой харьцуулсан

Барааны нэр төрөл	2015 I/28	2016 I/27	16 I /27 15 I/28
"Алтан тариа" дээд, савласан	1500	1500	100.0
гурил I зэрэг, задгай	960	1200	125
Орон нутгийн "Хангай" 1-р	880	910	103.4
гурил" "Орхон мандал"	800	950	118.8
1-р гурил			
Талх "Ундрах" аймгийн үйлвэр	900	1000	111.1
Цагаан будаа	2400	2500	104.2
Элсэн чихэр	1800	1800	100
Сүү Задгай	1500	2000	133.3
"Цэвэр сүү"	2750	2700	98.2
Ургамлын тос, "Кларина"	3600	3600	100
Мах Үхрийн	7000	5500	78.6
Хонины	5500	4500	81.8
Адууны	5500	4000	72.7
Ямааны	4500	3500	77.8
Төмс /монгол/	1200	1000	83.3
Лууван /монгол/	1000	2000	200
Байцаа /хятад/	1000	1000	100
Ногоо Манжин /монгол/	1500	2000	133.3
Сонгино /монгол/	2500	2500	100
Сонгино /хятад/	1500	1500	100
Сармис	300	350	116.7


*Хүнсний гол нэр төрлийн барааны ажиглалт, жил бүрийн 1-сарын байдлаар*

Барааны нэр төрөл		Хэмжих нэгж	2012 I	2013 I	2014 I	2015 I	2016 I	2016 I / 2015 I
"Алтан тариа"	I зэрэг	кг	950	950	1200	1300	1283	98.7
гурил /задгай/	II зэрэг	кг	700	700	700	900	1000	111.1
Будаа	Цагаан	кг	1800	1800	2300	2400	2433	101.4
	Шар	кг	1500	1500	1700	1900	1900	100.0
Элсэн чихэр		кг	1800	1800	1800	1800	1800	100.0
Хонины мах	ястай	кг	4500	6000	6500	5500	4000	72.7
	цул	кг	4500	6000	6500	5500	4000	72.7
Үхрийн мах	ястай	кг	5000	6500	7500	7000	5500	78.6
	цул	кг	5000	7000	7500	7000	5500	78.6
Адууны мах		кг	3800	5000	5500	5500	4000	72.7
Ямааны мах		кг	3500	4000	4500	4000	3500	87.5
Сүү	задгай	л	1200	1500	1300	1500	1500	100.0
	"Цэвэр сүү"	л	1800	1800	2250	2750	2700	98.2
Байцаа	монгол	кг	900	1000	800	1000	1000	100.0
Лууван	монгол	кг	800	800	1000	1000	2000	200.0
Манжин	монгол	кг	800	800	1500	1500	2000	133.3
Төмс	монгол	кг	800	800	800	1200	1000	83.3
Сонгино	хятад	кг	1000	1300	1500	1500	1500	100.0
Сармис, булцуу		кг	300	300	300	300	350	116.7
Ургамлын тос		л	3000	3000	3500	3600	3566	99.1
Өндөг		ш	250	250	420	400	300	75.0
Талх "Ундрах" орон нутгийн		ш	650	650	750	900	1066	118.4


*Нэг литр шатахууны үнэ, 2016 оны 1-р сарын байдлаар*

ШТС	АИ 95	АИ 92	АИ 80	Дизиль түлш	Газ
Шунхлай	0	1590	1480	1690	0
Тэс	0	1580	1470	1680	0
Магнай трейд	0	1590	1480	1690	0
Жаст ойл	0	1590	1480	1690	0
Петровис	1760	1590	1480	1690	0
Газ	0	0	0	1690	1100


*Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, жил бүрийн 1-р сарын байдлаар*



## Нэг кг хонины махны үнэ, төгрөг



## Нэг кг үхрийн махны үнэ, төгрөг



## Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, сараар, төгрөгөөр

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2015 I	2016 I
1	Гахайн мах	кг	-	6000
2	Тахиан мах	кг	-	3000
3	Цагаан ноолуур	кг	50000	-
4	Бор ноолуур	кг	50000	-
5	Адууны шир	ш	35000	30000
6	Үхрийн шир 1.8-2.3 метрийн хэмжээтэй шир	ш	40000	20400
7	Үхрийн шир 2.3 метрээс дээш хэмжээтэй шир	ш	60000	37000
8	Хонины ноостой нэхий	ш	5000	700
9	Ямааны арьс	ш	15000	8200

## Малын зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 1-р сарын байдлаар, төгрөгөөр

№	Бүтээгдэхүүний нэр	2015 I	2016 I
1	<b>Буур</b>	980000	950000
2	Нас гүйцсэн ат	1020000	840000
3	Нас гүйцсэн ингэ	820000	700000
4	Эр шилбэ	580000	487500
5	Эм шилбэ	550000	475000
6	Эр ботго	212500	225000
7	Эм ботго	212500	225000
8	<b>Азарга</b>	1050000	1095000
9	Соёолон үрээ	790625	611333
10	Соёолон гүү	765000	564286
11	Шүдлэн үрээ	536250	378000
12	Шүдлэн байдас	525000	372000
13	Эр унага	205000	167000
14	Эм унага	205000	169000
15	<b>Бух</b>	1193571	1065385

16	Хязаалан шар	1109375	825000
17	Хязаалан дөнж	937500	690625
18	Шүдлэн эр үхэр	678750	526250
19	Шүдлэн гунж	676250	460000
20	Эр тугал	230833	173636
21	Эм тугал	239167	163636
22	<b>Хуц</b>	187692	157857
23	Эр хонь	161250	120000
24	Эм хонь	121125	84063
25	Эр төлөг	87813	56875
26	Эм төлөг	86813	56563
27	Эр хурга	45769	29167
28	Эм хурга	45615	29167
29	<b>Ухна</b>	140769	114643
30	Эр ямаа	114563	88125
31	Эм ямаа	87375	66250
32	Эр борлон	61875	41750
33	Эм борлон	61875	40813
34	Эр ишиг	35385	20833
35	Эм ишиг	35769	20833

Адууны үнэ, сумаар, мян.төг, жил бүрийн 1-р сарын байдлаар

Сумын нэр	Нас гүйцсэн адуу				Өсвөр насны адуу			
	Морь		Гүү		Эр		Эм	
	2015 I	2016 I	2015 I	2016 I	2015 I	2016 I	2015 I	2016 I
Булган	800	700	800	700	500	500	500	500
Баян-Агт	650	-	620	-	480	400	480	400
Баяннуур	800	500	800	400	600	300	500	280
Бугат	800	800	850	800	520	650	520	650
Бүрэгхангай	800	500	800	500	600	550	600	550
Гурван булаг	900	700	900	-	750	-	750	-
Дашинчилэн	750	550	620	450	500	350	500	300
Могод	900	700	900	700	500	300	500	300
Орхон	750	600	750	550	600	350	600	350
Рашаант	650	550	550	500	350	370	300	350
Сайхан	700	600	600	450	350	300	300	300
Сэлэнгэ	1000	500	800	500	700	300	700	250
Тэшиг	800	550	800	550	500	400	500	400
Хангал	800	800	800	700	650	400	650	450
Хишиг-өндөр	700	620	800	600	480	300	500	300
Хутаг-Өндөр	850	500	850	500	500	200	500	200

## Тэмээний үнэ, сумаар, мян.төг жил бүрийн 1-р сарын байдлаар

Сумын нэр	Нас гүйцсэн тэмээ				Өсвөр насны тэмээ			
	Ат		Ингэ		Эр		Эм	
	2015 I	2016 I	2015 I	2016 I	2015 I	2016 I	2015 I	2016 I
Баяннуур	1000	700	800	600	500	400.0	500	400
Бүрэгхангай	1100	900	900	800	750	700	750	700
Дашинчилэн	900	700	800	600	600	400	550	400
Могод	900	900	800	700	450	450	450	400
Сайхан	1000	1000	800	800	600	-	500	-

## Үхрийн үнэ, сумаар, мян.төг, жил бүрийн 1-р сарын байдлаар

Сумын нэр	Нас гүйцсэн үхэр				Өсвөр насны үхэр			
	Эр		Эм		Эр		Эм	
	2015 I	2016 I	2015 I	2016 I	2015 I	2016 I	2015 I	2016 I
Булган	1000	900	1000	850	800	700	800	650
Баян-Агт	1100	800	1000	700	750	500	750	500
Баяннуур	1500	600	1000	500	800	500	800	400
Бугат	1500	1000	1200	950	700	600	750	600
Бүрэгхангай	1000	800	800	700	600	550	600	-
Гурван булаг	900	800	900	400	800	600	800	400
Дашинчилэн	950	700	850	550	750	520	720	-
Могод	1500	800	1000	700	500	500	500	500
Орхон	1100	600	900	550	600	500	600	500
Рашаант	950	1100	700	750	500	700	450	600
Сайхан	1200	800	1000	700	650	450	650	450
Сэлэнгэ	1300	1300	1200	1000	900	400	900	450
Тэшиг	900	700	800	600	650	450	700	450
Хангал	1000	700	1000	700	600	500	600	500
Хишиг-өндөр	1100	700	900	500	760	450	700	400
Хутаг-Өндөр	750	900	750	900	500	500	500	500

## Хонь, ямааны үнэ, сумаар, мян.төг жил бүрийн 1-р сарын байдлаар

Сумын нэр	Нас гүйцсэн хонины үнэ				Нас гүйцсэн ямааны үнэ			
	Эр		Эм		Эр		Эм	
	2015 I	2016 I	2015 I	2016 I	2015 I	2016 I	2015 I	2016 I
Булган	150	100	120	90	100	90	80	80
Баян-Агт	200	120	160	80	140	80	60	90
Баяннуур	150	80	100	45	100	60	30	80
Бугат	150	160	140	140	120	120	100	120
Бүрэгхангай	150	100	120	90	100	90	70	80
Гурван булаг	100	150	90	80	60	100	60	60
Дашинчилэн	140	90	90	55	120	70	35	70
Могод	180	150	140	80	120	80	80	100
Орхон	180	100	130	80	130	90	80	100

Рашаант	140	120	100	55	90	120	55	60
Сайхан	120	100	90	80	75	80	50	50
Сэлэнгэ	180	100	150	120	120	90	80	100
Тэшиг	220	150	120	80	120	80	70	90
Хангал	200	150	150	100	200	80	70	150
Хишиг-өндөр	170	150	118	70	138	90	50	88
Хутаг-Өндөр	150	100	120	100	100	90	90	80

## II.6 МАЛ АЖ АХУЙ

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар ,2016 оны 1-р сарын байдлаар

Сум	Хорогдсон том мал						Оны эхний малд эзлэх хувь					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Баян-Агт	107	49	20	0	15	23	0	0.3	0.1	0	0	0
Баяннуур	421	13	45	0	154	209	0.3	0.2	0.4	0	0.2	0.5
Бугат	1	0	1	0	0	0	0	0	0	0	0	0
Бүрэгхангай	105	8	11	0	31	55	0	0	0.1	0	0	0.1
Гурван булаг	980	44	50	0	504	382	0.3	0.2	0.3	0	0.3	0.3
Дашинчилэн	645	25	77	0	257	286	0.3	0.1	0.5	0	0.2	0.4
Могод	104	0	6	0	57	41	0	0	0	0	0	0.1
Орхон	186	40	9	0	82	55	0.1	0.1	0	0	0.1	0.1
Рашаант	358	12	25	0	115	206	0.2	0.1	0.3	0	0.1	0.3
Сайхан	205	30	15	0	100	60	0.1	0.1	0.1	0	0.1	0.1
Сэлэнгэ	8	5	2	0	0	1	0	0.1	0	0	0	0
Тэшиг	94	19	24	0	28	23	0.1	0.3	0.2	0	0.1	0.1
Хангал	6	1	5	0	0	0	0	0	0.1	0	0	0
Хялганат	31	0	8	0	11	12	0.2	0	0.2	0	0.2	0.2
Хишиг-өндөр	425	18	26	0	141	240	0.2	0.1	0.2	0	0.1	0.4
Хутаг-Өндөр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн	3676	264	324	0	1495	1593	0.1	0.1	0.1	0.0	0.1	0.2

## Хорогдсон хээлтэгч, сумаар, 2016 оны 1-р сарын байдлаар

Сум	Өвчнөөр хорогдсон том мал					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	0	0	0	0	0	0
Баян-Агт	3	2	1	0	0	0
Баяннуур	0	0	0	0	0	0
Бугат	1	0	1	0	0	0
Бүрэгхангай	13	1	0	0	5	7
Гурван булаг	0	0	0	0	0	0
Дашинчилэн	0	0	0	0	0	0
Могод	0	0	0	0	0	0
Орхон	0	0	0	0	0	0
Рашаант	0	0	0	0	0	0
Сайхан	0	0	0	0	0	0
Сэлэнгэ	0	0	0	0	0	0
Тэшиг	5	0	3	0	2	0
Хангал	5	0	5	0	0	0
Хялганат	0	0	0	0	0	0
Хишиг-өндөр	10	0	0	0	5	5
Хутаг-Өндөр	0	0	0	0	0	0
Дүн	37	3	10	0	12	12

## Өвчнөөр хорогдсон том мал, сумаар, 2016 оны 1-р сарын байдлаар

Сум	Хорогдсон хээлтэгч					
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Булган	0	0	0	0	0	0
Баян-Агт	6	3	0	0	3	0
Баяннуур	16	2	14	0	0	0
Бугат	0	0	0	0	0	0
Бүрэгхангай	21	2	4	0	7	8
Гурван булаг	245	6	10	0	149	80
Дашинчилэн	154	6	32	0	50	66
Могод	0	0	0	0	0	0
Орхон	0	0	0	0	0	0
Рашаант	0	0	0	0	0	0
Сайхан	55	5	5	0	25	20
Сэлэнгэ	0	0	0	0	0	0
Тэшиг	61	8	10	0	25	18
Хангал	2	0	2	0	0	0
Хялганат	0	0	0	0	0	0
Хишиг-өндөр	31	1	0	0	0	30
Хутаг-Өндөр	0	0	0	0	0	0
Дүн	591	33	77	0	259	222





**Холбоо барих**  
Монгол улс, Булган аймаг, Булган  
сум, Засаг даргын тамгын газар,  
Статистикийн хэлтэс  
**Утас:** 70342766  
**И-мэйл:** [bulgan@nso.mn](mailto:bulgan@nso.mn)  
**вэб:** [www.bulgan.nso.mn](http://www.bulgan.nso.mn)

**Contact us**  
*Statistical division, Governors office*  
*Bulgan sum, Bulgan aimag, Mongolia*  
**Phone:** 70342766  
**E-mail:** [bulgan@nso.mn](mailto:bulgan@nso.mn)  
**Web:** [www.bulgan.nso.mn](http://www.bulgan.nso.mn)